



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 8/11

Ховд


Л.Гэрэлмаад цалинтай чөлөө олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.1, 100.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.3-ын “а” дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Лхагвасүрэнгийн Гэрэлмаа нь зайлшгүй шаардлагаар чөлөө хүссэн тул 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Л.Гэрэлмааг чөлөөтэй байх хугацааны цалинг бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД